



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/02

Улаан-Уул

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хороодыг байгуулж, чиглэл, ажиллах
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.5, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, Хурлын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий 4 (дөрөв) хороог байгуулж бүрэлдэхүүн, чиглэлийг 1 дүгээр хавсралтаар, хороодын ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангаж, хорооны ажлын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг хороодын дарга нарт даалгасугай.

3. Хороодыг ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.


ДАРГА  С.ГОНГОР

Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр

D:\dok\ИТХ-8 дахь удаагийн сонгууль\6-р хуралдаан\тогтоол.docx

1818175

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ**

№	Хурлын хорооны нэр	Үйл ажиллагааны чиглэл	№	Хорооны бүрэлдэхүүн
1	2	3	4	5
1	Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороо	<ul style="list-style-type: none"> -Хүн амын эрүүл мэндийн бодлого -Хүн амын боловсролын бодлого -Хүн амын соёл, урлаг, спортын үйлчилгээний асуудал -Ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дээшлүүлэх асуудал -Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн нийгмийн халамж үйлчилгээний асуудал -Гэр бүл, хүүхэд, залуучууд болон эмэгтэйчүүдийн талаархи бодлого -Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн даатгал, цалин тэтгэвэрийн асуудлууд -Жендэр, хүний эрхийн асуудал -Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хамтын ажиллагаа -Бусад холбогдох асуудлууд 	1	Г.Баттогтох
			2	В.Түвшинсайхан
			3	С.Лувсанцэрэн
			4	Г.Батжаргал
			5	П.Доржбат
2	Хууль эрх зүй, хяналт үнэлгээний асуудал эрхэлсэн хороо	<ul style="list-style-type: none"> -Төр, засгийн хууль тогтоомж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээг хийх, сурталчлах -Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх - Хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах - Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх - Гамшгаас хамгаалах тухай, гамшигийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх аргачилал журмын хэрэгжилт, гамшигийн үед ажиллах бэлтгэл, бэлэн байдлын асуудал -Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй байдал, түүний хэрэгжилт -Төрийн бус байгууллага, шашны байгууллага -Бусад холбогдох асуудлууд 	1	С.Гонгор
			2	Д.Цэдэнсодном
			3	Ж.Ганболд
			4	Э.Ариунбилэг
			5	Г.Энхбат
3	Эдийн засаг хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн хороо	<ul style="list-style-type: none"> -Сумын эдийн засгийн стратегийн асуудлууд -Төсвийг зохистой хуваарилах, зардлыг хэмнэх -Аж үйлдвэр, барилга зам, тээвэр, холбоо, гадаад дотоод худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх -Орон нутгийн арилжааны банкны салбартай хамтран ажиллах. хөгжүүлэх -Статистик мэдээллийг боловсронгуй болгож, иргэдэд мэдээлэх. ашиглах -Үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт 	1	Т.Эрдэнэбат
			2	Б.Өлзийбаатар
			3	Р.Эрдэнэбат
			4	Ш.Ариунжаргал
			5	А.Эрдэнэбат

1	2	3	4	5
		<p>-Байгаль орчин, газрын харилцааны асуудал -Аялал жуулчлал, гадаад харилцааны хөгжүүлэх бодлого -Аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын мөрөөр зохиох ажлын хэрэгжилт -Төрийн болон орон нутгийн өмч, өмчийн хадгалалт, хамгаалалт, хувьчлалын асуудал -Ашиглагдаагүй нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинжлэх ухааны ололт, тэргүүний технологи нэвтрүүлэх - Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх -Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого -Хүн амын хүнсний хангамж, чанар эрүүл ахуйг сайжруулах бодлого -Үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, татварын баазыг өргөжүүлэх бодлого -Жижиг, дунд үйлдвэр, хоршоог хөгжүүлэх бодлого -Дэд бүтэц, хот байгуулалт, архитектур төлөвлөлт, стратегийн бодлого -Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагууд -Бусад холбогдох асуудлууд</p>		
4	Ёс зүйн хороо	<p>-Төлөөлөгчийн нийгмийн харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг зохицуулж, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчлийг шийдвэрлэх. -ИТХ-ын төлөөлөгч нь улс төр, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч мөн гэсэн хуулиар хүлээлгэсэн үүргийг сахин мөрдүүлэх -Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.</p>	1	С.Бат
			2	Ц.Элбэгбаяр
			3	Х.Одгэрэл
			4	А.Мөнхцэцэг
			5	Г.Нямдаваа